

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ
 ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
 ДАВАА Б.МӨНГӨНХУЯГ
 2024 оны... дугаар... сарын.....

9023090504
 9088822-9-СЕТ2305

ТОХИЖИЛТ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ЗУРАГ
 ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ ЗУРГИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 12 дугаар сарын 23

Дугаар 24/202

Улаанбаатар хот

1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл	- Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 25-ний өдрийн 05 тогтоол, Баянгол дүүргийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/558 дугаар захирамж
2.	Байршил, эдэлбэр газрын хэмжээ	- Баянгол дүүргийн 20 дугаар хороонд 10000 м2 талбайд тохижилт хийх болон хашаа, хайс, явган зам зэрэг ажлууд хийх;
3.	Зориулалт, хүчин чадал	Орчны нөхцөл байдалд уялдуулан - Бейсболын талбай 100*90 м нийт 9000 м2; - Явган зам 1000 м2; - Тохижилт, хашаа хайс; - Ногоон байгууламж
7.	Зураг төслийн иж бүрдэл	<u>Баримт бичгийн иж бүрдэл:</u> - Одоогийн байдлын фото зураг - Ашиглагч байгууллагуудтай ажлын тоо, хэмжээ зөвшилцсон хурлын тэмдэглэл. - Мэргэжлийн хяналт болон Онцгой байдлын дүгнэлт /шаардлагатай тохиолдолд/ - Магадлалын дүгнэлт /хавсралтын хамт/; <u>Ажлын зургийн иж бүрдэл:</u> - Хэмжилтийн, өөрчлөлтийн ажлын зураг; - Өрөө тохижуулах рендер зураг; - Гадна инженерийн шугам сүлжээ /шаардлагатай тохиолдолд/;
8.	Төсөл боловсруулах үе шат	Ажлын зураг төсөв нэг үе шаттай: Ажлын зураг, төсөв боловсруулж, батлуулах;
4.	Зураг төсөлд тавигдах шаардлага:	- Тохижилтын элементүүдийг норм дүрмийн дагуу төлөвлөх ба ерөнхий харагдах байдлыг 3D буюу 3 хэмжээст зураглалаар гүйцэтгэх; - Зураг төслийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээж авахад тавигдах шаардлага; а. Хот байгуулалтын мэдээллийн сангийн стандартыг мөрдөх; б. Хийгдэж буй төслийн дэвсгэр зургийн WGS-84, UTM буюу солбицлын нэгдсэн тогтолцоонд хийж гүйцэтгэх;
5.	Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	- Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгох;

6.	Зураг төслийн байгууллага	- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий хуулийн этгээд;
7.	Хөрөнгө оруулагч (захиалагч байгууллага)	- Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар;
8.	Инженерийн хангамж	- Эрх бүхий байгууллагаас холбогдох техникийн нөхцөлийг авч, техникийн нөхцөлийн дагуу зураг төсвийг боловсруулан хийж гүйцэтгэх;
9.	Онцгой нөхцөл	<p><u>Анхаарах зүйл:</u></p> <ul style="list-style-type: none"> - Суурийн материал: Шаварлаг шинж чанаргүй уулын буталсан, шигшсэн чулуу буюу хайрга дайрга хийх; - Суурийн зузаан: Хөрсний шинж чанар, хөрсний усны түвшнээс хамаарч харилцан адилгүй байх бөгөөд хамгийн багадаа 30-40 см зузаантай байх; - Хайрган суурийн бүтэц: <ul style="list-style-type: none"> ✓ Суурь үе: 150-200 мм зузаантай бөгөөд 20-40 мм фракцтай буталсан чулуугаар хийх; ✓ Дунд үе: 150 мм зузаантай бөгөөд 10-20 мм фракцтай хайрга, дайрга байх; ✓ Дээд үе: 20 мм зузаантай 0.5 мм фракцтай хайрга, дайрга байх; - Чанартай хиймэл зүлэг, зориулалтын зөөлөвч резин дэвсгэр хэрэгслээр хийх; - Зөөлөвч дэвсгэрийг хайрга дайрган суурин дээр, хиймэл зүлгийн доор дэвсэх бөгөөд хооронд нь тусгай зориулалтын скочоор нааж байрлуулах; <ul style="list-style-type: none"> ✓ Материал: Байгаль орчинд ээлтэй резин байх; ✓ Зузаан: 10-15 мм байх; ✓ Жин: 720 гр/м2 байх; ✓ Нягт: 50 кг/м2 байх; ✓ Хэмжээ: 9000 м2 байх; - Хиймэл зүлгийн загвар олон улсын лабораторийн дүгнэлттэй байх; <ul style="list-style-type: none"> ✓ Чанартай байгальд ээлтэй байх; ✓ Зүлгийн өндөр: 15-20 мм байх; ✓ Хэмжээ: 9000 м2 байх; - Кварцын элс: 0.5 мм гадаргуутай байх бөгөөд 1 м2 талбайд 15-20 кг байх; - Тендерт үнийн санал ирүүлэхдээ газар дээр нь судалж, ажлын тоо хэмжээг тооцож ирүүлэх; - Ажлын зураг төсвийг боловсруулж, магадлалаар баталгаажуулсны дараа угсралтын ажлыг эхлүүлэх; - Явган хүний замын чиглэл, хөдөлгөөний эрчмийг тооцоолох; - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангах; - Борооны ус зайлуулах байгууламж тооцох;
10.	Төлөвлөлтөд тавигдах шаардлага	<p><u>Дараах байгууллагуудтай заавал зөвшилцсөн байна:</u></p> <ul style="list-style-type: none"> - Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар;

		- Холбогдох бусад байгууллагуудтай;
11.	Ерөнхий төлөвлөгөө, зураг төсөв боловсруулах	<p><u>Хууль тогтоомжууд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль; - Барилгын тухай хууль; - Газрын тухай хууль; - Хот байгуулалтын тухай хууль; <p><u>Норм, нормативууд:</u></p> <ul style="list-style-type: none"> - "Хотын стандарт-Ногоон байгууламжийн төлөвлөлтөд тавих шаардлага" UCS 0801A стандартыг мөрдөх; - "Хотын стандарт-Гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавих шаардлага" UCS 1901B, UCS 1902A стандартыг мөрдөх; - "Хотын стандарт-Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих шаардлага" UCS 0901B стандартыг мөрдөх; - "Хотын стандарт-Саравч, сүүдрэвчинд тавигдах ерөнхий шаардлага" UCS 1404B стандартыг мөрдөх; - "Хотын стандарт-Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага" UCS 1405B стандартыг мөрдөх; - "Хотын стандарт-Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байршуулах хогийн саванд тавих шаардлага" UCS 1406B стандартыг мөрдөх; - "Хотын стандарт-Нийтийн эзэмшлийн талбайд сандалд тавих ерөнхий шаардлага" UCS 1407B стандартыг мөрдөх; - "Хотын стандарт-Хашаа, хайс, хашлаганд тавих ерөнхий шаардлага" UCS 1410B стандартыг мөрдөх; - Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар (MNS6056:2009) - "Хотын стандарт-Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, хучилтад тавих ерөнхий шаардлага" /UCAS 0902B/ - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30-01-04/; - Барилгын орчны тохижилтын ажлын норм ба дүрэм /БНБД 3.01-06-90/; - Барилгын төсөв зохиох дүрэм БНБД 81-95-12 - Бусад холбогдох норм, дүрэм
12.	Эдийн засгийн тооцоо, төсөв	- Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох;

ХЯНАСАН:
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Г.ЭНХЦЭНГЭЛ

БОЛОВСРУУЛСАН:
ТӨЛӨВЛӨЛ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.АСЕМГУЛ